



БСШУЯ-НЫ ХАРЬЯА  
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

---

## **2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот 2014 он

## АГУУЛГА

### Нэг. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1. Бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин
- 1.2. Төсөв, санхүү
- 1.3. Хамтын ажиллагаа

### Хоёр. 2014 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

- 2.1. Бодлого, судалгаа, арга зүй
- 2.2. Зохион байгуулсан сургалт, уулзалт
- 2.3. Орон нутгийн төвөөс иргэдэд зохион байгуулсан сургалт
- 2.4. Төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт
- 2.5. Сургалтын боловсруулсан материал
- 2.6. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ
- 2.7. Бусад ажил

### Гурав. ДҮГНЭЛТ, ТӨЛӨВЛӨЛТ

- 3.1. Дүгнэлт

### Дөрөв. ХАВСРАЛТУУД

- Хавсралт-1** *Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөрийн төсөл*
- Хавсралт-2** *Боловсролын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах санал*
- Хавсралт-3** *Насан туршийн боловсролын сургалтын багц хөтөлбөр*
- Хавсралт-4** *Үндсэн 5 чиглэлийн сургалтад хамрагдсан иргэдийн тоон үзүүлэлт*
- Хавсралт-5** *Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдсан иргэдийн тоон үзүүлэлт*
- Хавсралт-6** *Бичиг үсгийн боловсрол олгох сургалтад хамрагдагсад:*

### **1.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БОЛОВСОН ХҮЧИН**

Монгол улсын Засгийн газрын 1997 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 116 дугаар тогтоолоор Монгол улсад албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. 1997 оноос Албан бус боловсролын төв болгон зохион байгуулж Гэгээрлийн яаманд харьяалуулсан.

2002 онд Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв,

2012 онд Насан туршийн боловсролын үндэсний төв болж хот, хөдөө, орон нутагт үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэн ажиллаж байна.

Төв нь насан туршийн боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах, бодлогын хэрэгжилтийг үндэсний түвшинд зохион байгуулах, орон нутгийн боловсролын байгууллага, хүний нөөцийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт, судалгаа, арга зүйн байгууллага юм.

Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2013 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/242 тоот тушаалаар Насан туршийн боловсролын үндэсний төвийн чиглэл, дүрэм, бүтцийг баталсан бөгөөд төв нь үйл ажиллагааны хэлтэс, ажлын албатай байх ба дараах бүтэцтэй байна гэж тодорхойлсон.

- 1) Үйл ажиллагааны хэлтэс: Сургалт, судалгаа, хөтөлбөрийн мэргэжилтэн, төлөвлөлт, маркетингийн мэргэжилтэн, харилцаа, хамтын ажиллагааны мэргэжилтэн, мэдээлэл технологийн мэргэжилтэн
- 2) Ажлын алба: Хүний нөөц-бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч, теле студи, хэвлэх цехийн ажилтнаас бүрдэнэ гэж заасан.

Одоогийн байдлаар:

- Захирал- 1
- Мэргэжилтэн-7
- Студийн найруулагч-1
- Хэвлэлийн техникч-эх бэлтгэгч-1
- Хэвлэгч-1
- Хүний нөөц-бичиг хэргийн ажилтан -1
- Нягтлан бодогч-1 нийт 13 хүний орон тоотойгоор ажиллаж байна.

**1.2. Төсөв, санхүү:**      **Улсын төсвөөс:**      ... төгрөг  
                                         **Өөрийн орлогоос:**      ... төгрөг  
                                         **Үүнээс:**                              хэмнэлт гаргасан

### **1.3. Хамтын ажиллагаа**

Тус байгууллага нь гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүрээгээ тэлэн ажиллаж байна. Ялангуяа гадаад болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд дараах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрээд байна.

**Гадаад хамтын ажиллагаа:**

НТБҮТ-ийн үйл ажиллагааны тодорхой хэсэг нь олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд явагддаг. Тухайлбал:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /UNESCO/
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан /UNICEF/
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан /UNFPA/
- Швейцарийн Хөгжлийн Агентлаг /SDC/
- Люксембургийн Засгийн Газар /LDG/
- Японы хүүхдийг ивээх сан /Save The Children Fund Japan/

- Дэлхийн зөн /World Vision International/
- Адра Монгол /ADRA Mongolia/ зэрэг олон улсын байгуулагатай хамтран ажиллаж байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд доор дурдсан байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ гадны орнуудад болсон бүсийн болон олон улсын хэмжээний хурал чуулган, сургалт- семинарт оролцож илтгэл тавьж харилцан туршлага солилцох ажлыг 2014 онд хийж гүйцэтгэв.

- Индонез улсын нийслэл Жакарта хотод 2014 оны 08 дугаар сард “Орон нутгийн иргэдийн сургалтын төвөөр дамжуулан боловсрол олгох” сэдэвт олон улсын хуралд захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Цэндмаа оролцов.
- Насанд хүрэгчдийн боловсролын чиглэлээр 2014 оны 3 дугаар сард ахлах мэргэжилтэн Т.Хантулга Ази, Номхон далайн бүсийн орнуудын “Бүх нийтийн боловсрол 2015” хуралд оролцов.
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын MonDeNara Consulting, НКW (Герман улсын Лейпциг хотын Гар урлалын танхим), ИНК (Үйлдвэрлэл, худалдааны танхим), Хемниц хотын Насан туршийн боловсролын төв зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлах, мэргэжилтэн солилцох хөтөлбөрийн төслийг хэлэлцэн 2015 оны 1 дүгээр улирлаас хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

**Дотоод хамтын ажиллагаа:** Аймаг, нийслэлийн Албан бус-насан туршийн боловсролын төв, нэгжийн багш, арга зүйч нар болон бүх шатны удирдлагуудаас гадна доорх нэр бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллав. Тухайлбал:

- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
- Эрүүл мэндийн яам
- Хууль зүйн яам
- Байгаль орчин ногоон хөгжлийн яам
- Соёл, спорт аялал жуулчлалын яам
- Монголын үндэсний олон нийтийн телевиз
- Хүүхдийн төлөө үндэсний газар
- Монгол улсын боловсролын их сургууль
- Боловсролын хүрээлэн
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Бүх нийт боловсрол эвсэл
- Хувь хүний хөгжлийн институт
- Ашид өрнөх эрүүл мэнд мэдлэг ТББ

#### ***Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд***

- Японы Хүүхдийг ивээх сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “ Монголын алслагдсан хөдөө, орон нутгийн бага насны хүүхдэд бага боловсрол нөхөн олгох” чиглэлээр хамтран ажиллах ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав. Тус төслийн хүрээнд Насан туршийн боловсролын үндэсний төв, Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгуудын Албан бус-Насан туршийн боловсролын төв, 30 сумын Насан туршийн боловсролын нэгжид тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлж эхлээд байна.
- “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийг Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Люксембургийн Засгийн Газар НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн Газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монгол улсын Боловсролын их сургуультай хамтран хэрэгжүүлж байна.
- НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр сүм хийдэд шавилан сууж буй лам хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг нь хангах зорилгоор Завхан аймгийн Төгсбуянт, Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал, Улаанбаатар хотын Гандантэгчилэн хийдүүдэд боловсрол нөхөн олгох

сургалтуудыг зохион байгуулав.

### **2015 онд хамтран ажиллах байгууллагууд**

НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна дараах байгууллагуудтай санал солилцов.

- АДРА-Монгол ОУБ-ын захирал Ореллана Жошетай уулзаж 2015 онд хамтран ажиллах тухай харилцан ярилцаж санал солилцов.
- Европын Холбооны мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төслийн зохицуулагч Петер Мелинтонтой уулзаж хамтран ажиллах талаар санал солилцов.
- Японы хүүхдийг ивээх сангийн Хүүхдийн цирк төслийг хамтран хэрэгжүүлэх
- БНСУ-ын Сөүл хотын Боловсролын газрын дарга Пак Чи Дун (*Насан туршийн боловсролын доктор*) мэргэжилтнүүдийн хамт ирж хамтарч ажиллахаар НТБҮТ-ийн захирал Л.Болортунгалагтай санал бодлоо солилцов.

## **ХОЁР. 2014 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ**

### **2.1. БОДЛОГО, СУДАЛГАА, АРГА ЗҮЙ**


Бодлого, судалгаа, арга зүйн чиглэлээр 2014 онд дараах ажлыг хийж гүйцэтгэв:

- Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, 2014 оны 6 дугаар сард БСШУЯ-нд хүргүүлэв. (*Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 хэсгээс үзнэ үү.*)
- Боловсролын тухай хуулийн 1,3,5,6-р бүлэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 22 саналыг БСШУЯ-нд хүргүүлэв. (*Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2 хэсгээс үзнэ үү.*)
- БШУ-ны сайдын 2013 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/242 тоот тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс 2,75 хэв.хууд “*Насан туршийн боловсролын сургалтын багц хөтөлбөр*”-ийн төслийг боловсруулж Боловсролын хүрээлэнгээр дүгнэлт гаргуулан 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр БСШУЯ-нд хүргүүлэв. (*Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3 хэсгээс үзнэ үү.*)
- Бүх нийтийн боловсрол-2015 үндэсний тайлангийн эхний төсөл (20 хэв.хууд)-ийг англи хэл дээр боловсруулан гаргаж ЮНЕСКО-д хүргүүлэв.
- БСШУ-ны сайдын 2007 оны 362 дугаар тушаалаар батлагдсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам” -д оруулах саналын удирдамжийг боловсруулж, 21 аймаг, 9 дүүргийн Насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлж, 25 төвөөс ирсэн саналыг нэгтгэн боловсруулж БСШУЯ-нд 12 сард хүргүүлсэн болно.
- Төвийн мэргэжилтнүүд 18 улс орны насан туршийн боловсролын тогтолцоог судалж үндэсний хөтөлбөрт орох саналаа тусгаж ажиллав.
- Үндэсний хэмжээнд насан туршийн боловсролын салбарт ажиллаж буй нийт багш, арга зүйчдийг мэргэшүүлэх, давтан бэлтгэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаанд түүврийн аргаар 290 багшийг хамруулж судалгааны тайланг 2014 оны 11-р сард МУБИС-ийн Насан туршийн боловсролын тэнхимд хүргүүлэв.
- Тус төвийн цахим хуудсаар дамжуулан сонирхсон иргэн олон хувилбарт сургалтын материалуудыг татан авч, бие даан суралцах боломж бүхий нээлттэй сургалтын орчныг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэв. Үүнд 380 гаруй төрлийн сургалтын материал, төвийн үйл ажиллагааны болон хэрэгжүүлсэн төслүүдийн тайлан (англи, монгол хэл дээр), ЮНЕСКО болон олон улсын бусад байгууллагын цахим хуудсанд байрласан мэдээллүүд, НТБҮТ-ын

холбогдолтой бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг татаж авах боломжтойгоор байршуулав. Эдгээр сургалтын материалаас дүйцсэн хөтөлбөрийн 127 модулийг давхардсан тоогоор 38000 гаруй удаа татаж авсан байна. Мөн дээрх сургалтын материал болон бусад мэдээллүүдийг [www.nfde.mn](http://www.nfde.mn), [www.ncle.mn](http://www.ncle.mn), [насантуршийнболовсрол.мон](http://насантуршийнболовсрол.мон) гэсэн домайнуудаар дамжуулан түгээж байна.

- Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Эрдэм боловсролтой Монгол хүн” бүлгийн 187.12-т “Албан бус боловсролыг насан туршийн боловсролын хэлбэрт шилжүүлэн сургалтын агуулга, арга зүй, сурах бичиг, орчин, хэрэглэгдэхүүн, чанарын үнэлгээ, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх санхүүжилтийн тогтолцоог бий болгох” зорилт, БШУ-ны сайдын А/242 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор хөдөө орон нутагт Албан бус - насан туршийн боловсролын 21 бие даасан төв байгуулагдаж, 9 бие даасан төв байгуулахаар аймгийн Засаг даргын захирамж гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2014 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар 359 насан туршийн боловсролын салбар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 21 төв, 338 нэгж ажиллаж байна. Үүнд:

- Нийт улсын хэмжээнд 30 төв байгуулахаар зорин ажилласнаас захирамж гарч үйл ажиллагаагаа эхэлсэн 21 буюу 70%, захирамж гарсан ч үйл ажиллагаа нь эхлээгүй 9 буюу 30% байна.
- Захирамж гарч үйл ажиллагаа нь эхэлсэн төв хэв шинжийн хувьд 4 буюу 19 хувь нь Засаг даргын тамгын газраа түшиглэж, 17 буюу 81 хувь нь бие даасан хэлбэрээр ажиллаж байна.
- Улсын хэмжээнд нийт 338 НТБ-ын нэгж байгаагаас 11 буюу 3% нь ЗДТГ түшиглэсэн, 337 буюу 97% нь ЕБС түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.



- Иргэдийн боловсролоо байнга, тасралтгүй дээшлүүлэх хэрэгцээг нь тандан судалж, тэдний боловсролын хэрэгцээ агуулгыг тодорхойлох зорилгоор Улаанбаатар хотын 8 дүүргийн 35315 иргэдийг хамруулсан насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээний судалгааг авч судалгааны тайланг гаргав. Мөн 21 аймгийн 330 сумын 55727 насанд хүрэгчдээс хэрэгцээний судалгааг авч судалгааг SPSS програмд оруулахад бэлтгээд байна.



Хүснэгт 1.Хамрагдагсдын тоо

Дүүрэг	Хамрагдсан хүний тоо
Баянгол	4358
Баянзүрх	12080
Багануур	1254
Чингэлтэй	4798
Сонгино-хайрхан	5094
Сүхбаатар	2377
Налайх	1153
Хан-Уул	4201

<b>Нийт 8 дүүрэг</b>	<b>35315</b>
Архангай	3500
Баян-Өлгий	2341
Баянхонгор	2800
Булган	2495
Говь-Алтай	1900
Говьсүмбэр	549
Дархан	3060
Дорноговь	2394
Дорнод	2506
Дундговь	1730
Завхан	1500
Орхон	5778
Өвөрхангай	3688
Өмнөговь	1956
Сүхбаатар	1464
Сэлэнгэ	3973
Төв	4252
Увс	2000
Ховд	3017
Хөвсгөл	2703
Хэнтий	2016
<b>Нийт 21 аймаг</b>	<b>55727</b>

## 2.2. ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, УУЛЗАЛТ

Албан бус - насан туршийн боловсролын төвүүдийг нийслэлийн 9 дүүрэг, баруун бүс, зүүн бүс, хангайн бүс, төвийн бүс, говийн бүсүүдэд хувааж (нийт Албан бус-насан туршийн боловсролын төвд 527 захирал, багш, арга зүйч) мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг тогтмол үзүүлж байна. Үүнээс гадна бусад байгууллагын захиалгаар сургалт зохион байгуулах, нэгжид хөтөлбөр, төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй үйл ажиллагааг арга зүйгээр хангах, удирдан зохион байгуулах зэрэг ажлыг өдөр тутам гүйцэтгэж байна.

2014 онд манай төвөөс зохион байгуулсан уулзалт, сургалтад бүх төвшний 717 хүн хамрагджээ (Хүснэгт 2).

*Хүснэгт 2. Зохион байгуулсан сургалтын тойм*

№	Сургалтын чиглэл	Хамрагдсан хүний тоо
1	“Боловсролын чанарын шинэчлэл - Насан туршийн боловсрол” үндэсний сургалт-семинар	90
2	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	257
3	“Боловсрол-хөгжлийн бэрхшээл: Тэгш эрх, тэгш боломж”	107
4	Малчин иргэдэд нөлөөллийн сургалт	250
	<b>Нийт</b>	<b>717</b>

### 1. “Боловсролын чанарын шинэчлэл - Насан туршийн боловсрол” үндэсний сургалт-семинар



“Орон нутагт иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцах боловсролын үйлчилгээг боловсонгуй болгох, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх олон нийтийн ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зорилготой үндэсний хэмжээний сургалт-семинарыг 2014 оны 5 дугаар сарын 22-23 өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав.

Сургалтанд аймаг, нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Боловсролын газрын дарга, Албан бус-насан туршийн боловсролын төвийн захирал зэрэг нийт 90 оролцов.

Уг сургалт зохион байгуулагдсаны үр дүнд орон нутгийн удирдлага боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэлтэй болж, насан туршийн боловсролын үйлчилгээ, хүүхэд хамгааллын талаарх ойлголт нь нэмэгдэж, хүүхэд, насанд хүрэгчдийн боловсролын ээлтэй үйлчилгээг явуулах Албан бус-насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг орон нутгийн байгууллагууд, хувь хүмүүсийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулснаар үр дүнд хүрнэ гэдгийг хүлээн зөвшөөрч, орон нутагт зохион байгуулах ажлынхаа урьдчилсан төлөвлөгөөг гаргаж хэлэлцлэв.

## 2. “Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”



“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага” сэдвийн хүрээнд Баян-Өлгий, Сүхбаатар, Дархан-Уул, Орхон, Дорнод, Дорноговь, Хэнтий, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, нийслэлийн 8 дүүрэг (9 аймаг, 8 дүүрэг)-ийн Албан бус - насан туршийн боловсролын төв болон нэгжийн давхардсан тоогоор 340, давхардаагүй тоогоор 257 багшийг хамруулсан сургалтыг зохион байгуулав.

Хүснэгт 3. Сургалтын тойм

№	Уулзалтын нэр, чиглэл	Хугацаа	Хамарсан хүрээ	Хамрагдсан тоо
1	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.2.27-28	Орхон	18
2	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.4.1-4	Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй	53
3	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.5.22-23	Сүхбаатар	33
4	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.10.28-29	Дорнод	41
5	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.11.12-13	Дорноговь	19
6	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.11.18-20	Ховд	16
7	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.11.22-24	Баянхонгор	23
8	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.12. 2-3	Хэнтий	26
9	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.12. 11-12	Дархан	11
10	“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”	2014.6.11-12	Баян-Өлгий	17
<b>Нийт</b>				<b>257</b>

## 3. “Боловсрол-хөгжлийн бэрхшээл: Тэгш эрх, тэгш боломж”



2014 оны 5 дугаар сарын 4-11-ний хооронд “Бүх нийтийн боловсрол” дэлхийн 7 хоногийг тохиолдуулан “Боловсрол-хөгжлийн бэрхшээл: Тэгш эрх, тэгш боломж” сэдвийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Боловсролд тэгш хамруулах тухай ойлголт хэлэлцүүлгийг “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, Боловсролын хамтын ажиллагааны



нийгэмлэгтэй хамтран зохион байгуулав.

Уг хэлэлцүүлэгт хуулийн төслийг боловсруулсан багийн гишүүд, төрийн болон төрийн бус байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болох 67 хүн оролцов. Мөн уг үйл ажиллагааны хүрээнд сэтгүүлчдэд мэдээлэл өгөх, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх, хүргэх, сурталчлах зорилгоор 25 байгууллагаас 40 сэтгүүлч оролцов.

#### 4. Малчин иргэдэд нөлөөллийн сургалт




“Ухаалаг иргэн хөгжлийн хөтөч” аяны хүрээнд 11 дүгээр сарын 23-ний өдөр Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгонд зохион байгуулагдсан "МАЛЧИН ФЕРМЕР" 1000-н малчны бүсчилсэн сургалтанд оролцож 250 малчин иргэдэд Насан туршийн боловсролын талаар танилцуулж, Албан бус-насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг сурталчилав.

### 2.3. ОРОН НУТГИЙН ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ

БШУ-ны сайд аймаг, нийслэлийн засаг дарга нарт Насан туршийн боловсролын төв, нэгжийг байгуулах тухай 2013 оны 1а/5618 тоот албан даалгавар өгснөөр 2014 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар 359 насан туршийн боловсролын салбар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 21 төв, 338 нэгж ажиллаж байна. Эдгээр төвүүд давхардсан тоогоор нийт 196008 иргэдэд сургалт явуулсан байна. Үүнд:

1. “Насан туршийн боловсролын талаар баримтлах бодлого”-д заасан 1) Гэр бүлийн боловсрол; 2) Иргэний боловсрол; 3) Ёс суртахуун-төлөвшилийн боловсрол; 4) Гоо зүй-мэдрэмжийн боловсрол; 5) Амьдрах ухааны боловсролоос гэсэн үндсэн 5 чиглэлээр Албан бус-насан туршийн боловсролын төв, нэгжүүд нийт 182 576 суралцагчдад давхардсан тоогоор сургалт явуулжээ. Үүнд:

- 1) Гэр бүлийн боловсрол - 22207
- 2) Иргэний боловсрол - 54257
- 3) Ёс суртахуун-төлөвшилийн боловсрол - 54329
- 4) Гоо зүй-мэдрэмжийн боловсрол - 14296
- 5) Амьдрах ухааны боловсрол – 37484




(Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү.)

2. **Дүйцсэн хөтөлбөр:** Сургуульд огт ороогүй хүүхэд залуус, сургууль завсардсан хүүхэд залуус, ерөнхий боловсрол эзэмших хүсэлтэй насанд хүрэгчид хамрагддаг боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад **10019** суралцагч хамрагдсан байна.

2014 онд Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад улсын хэмжээнд нийт 10019 суралцагч хамрагдсан байна. Үүнийг түвшингээр нь авч үзвэл:

- Бага боловсролд- 3585
- Суурь боловсролд- 4194


- Бүрэн дунд боловсролд- 2240 суралцагчид тус тус хамрагджээ.



Үүний үр дүнд 193 суралцагч ЕБС-ийн зохих ангид шилжин суралцаж 1068 суралцагч бага боловсрол эзэмшиж 1165 суралцагч суурь боловсрол, 919 суралцагч бүрэн дунд боловсрол эзэмшин гэрчилгээ авсан байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 5-аас үзнэ үү.)

3. **Бичиг үсгийн боловсрол:** Бичиг үсэг тайлагдах, бичиг үсгийн чадвараа дээшлүүлэх хүсэлтэй 10 болон түүнээс дээш насны 3413 суралцагчдад бичиг үсгийн сургалтыг зохион байгуулсан байна. Үүнээс:

- Анхан шат- 1152
- Дунд шат- 1101
- Гүнзгий шат- 753
- Бичиг үсгийн дараах- 407 суралцагч хамрагдсан байна.



(Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 6-аас үзнэ үү.)

## 2.4. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТУУД



НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн Газартай хамтран хэрэгжүүлж буй “Залуучуудын хөгжил /2013-2017/”-төслийг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр оролцов. Тус төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул, Орхон зэрэг нийт 11 аймаг, Улаанбаатар хотын Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төслийн хүрээнд:

- “Амьдрах ухааны боловсрол” олгох чиглэлээр үндэсний сургагч багш бэлтгэх сургалт амжилттай зохион байгуулагдлаа. Уг сургалтыг 7 өдөр танхимаар, 3 өдөр дадлагаар Албан бус-Насан туршийн боловсролын төв, Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн 350 оюутан суралцагдах туршилтаар зааж үндэсний хэмжээний 25 сургагч багш бэлтгэв.

- Үндэсний хэмжээнд бэлтгэгдсэн 25 сургагч багш 11 аймагт Албан бус-насан туршийн боловсролын төв, Их дээд сургууль болон ЕБС-ийн нийт 325 багш нарт “Амьдрах ухааны боловсрол” олгох сургалт зохион байгуулав. Уг сургалтад Албан бус-насан туршийн боловсролын төв болон нэгжийн 83 багш хамрагдсан нь нийт сургагч багшийн 25,8 хувийг эзэлж байна.
- Албан бус-насан туршийн боловсролын төв-11, ЕБС-5, Их дээд сургууль-4 түшиглэж нийт “Амьдрах ухааны 20 –н танхим”-ыг байгуулав. “Амьдрах ухааны танхим”-д сургалтын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор 36 сая төгрөгний засварын ажлыг хийв (*засварын мөнгийг НҮБ-ын Хүн амын сангаас шууд шилжүүлсэн*).
- Зорилтод бүлгийн Орон нутагт байгуулж буй “Амьдрах ухааны танхим”-ын үйл ажиллагааг жигдрүүлэх, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 126 сая төгрөгний сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдан авах, гарын авлага боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Албан бус боловсрол” дэд төслийн хүрээнд сүм хийдэд шавилан сууж буй лам хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг нь хангах зорилгоор Завхан аймгийн Төгсбуянт, Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал, УБ-ын Гандантэгчилэн хийдүүдэд 2 удаагийн дүйцсэн хөтөлбөрийн 60 хоногийн сургалтанд давхардсан тоогоор 274 хүүхдийн сургалтыг зохион байгуулав.

- Хүснэгт 4. Хамрагдсан тоо, байршил

№	Хийдийн нэр	Хүүхдийн тоо	
		I шатны сургалт	II шатны сургалт
1	Гандантэгчилэн хийд, УБ хот	65	98
2	Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал	29	26
3	Завхан аймгийн Төгс буянт	28	28
	<b>Нийт</b>	<b>122</b>	<b>152</b>

I шатны сургалтын үр дүн:

- Гандантэгчилэн хийдийн суралцагчдын 50 хувь нь боловсролын түвшингээ ахиулсан
- Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал хийдийн 8 лам хүүхэд суурь боловсролын гэрчилгээ авсан
- Завхан аймгийн Төгс буянт хийдийн 28 лам хүүхдүүд бага боловсрол эзэмшсэн байна.

## 2.4. СУРГАЛТЫН МАТЕРИАЛ

Манай төвөөс 2014 онд дараахь сургалтын материал, ном, гарын авлагыг боловсруулан хэвлэн түгээгээд байна. Үүнд:

- 1) Насанд хүрэгчдийн боловсролыг хөгжүүлэх ЮНЕСКО-гийн зөвлөмж, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын зөвлөмж-зааварчилгааг орчуулж 500 ширхэг хэвлэн төвүүдэд түгээсэн ба байгууллагын сайтад татаж авах боломжтойгоор байршуулав.
- 2) Амьдрах ухааны боловсролын чиглэлээр 15 нэр төрлийн 77.9 хэв.хуудас бүхий гарын авлага, сургалтын материалыг 6000 ширхэг хэвлэн “Залуучуудын хөгжил” төслийн хүрээнд байгуулагдаж буй Амьдрах ухааны 20 танхимд түгээхэд бэлтгэж байна.

- 3) НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд өөрөө чиглүүлэгч” хөтөлбөрийн хүрээнд 7 нэр төрлийн 43 хэв. хуудас бүхий сургалтын материал гарын авлагыг хэвлэн Налайх дүүргийн Албан бус-насан туршийн боловсролын төвд түгээж, сургалтын чанар, сургалтын материалын хүртээмжийг нэмэгдүүлэв.
- 4) Төвийн дотоод нөөц боломж болон бусад захиалгат ажлын хүрээнд 35 хэв.хуудас бүхий сургалтын материал, гарын авлага, судалгааны тайланг хэвлэн түгээв.

## **2.5. МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Энэ хэсгийг 1) Насан туршийн боловсролын мэдээллийн сан, 2) хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн хоёр чиглэлд ангилан дэлгэрүүлэе.

### **2.5.1. Насан туршийн боловсролын мэдээллийн сан**

- Аливаа үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь суурь судалгаа, мэдээллийн сангийн бааз байдаг билээ. Манай төв нь 2007 оноос эхлэн цахим мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг явуулж ирсэн ба төвийн бүтэц, зохион байгуулалт, сургалтын чиглэл өөрчлөгдсөнөөр хуучин Engine Education V1.0 мэдээллийн сангийн програм хангамжийг шинэчилэн Насан туршийн боловсролын мэдээллийн сангийн програм хангамжийг 16 нэр төрлийн 154 өгөгдөлтэйгөөр боловсруулав. Мэдээллийн сангийн программын үр дүнд насан туршийн боловсролын сургалтын нэр төрөл, суралцагчид, албан бус-насан туршийн боловсролын төвүүдэд ажиллаж буй ажилтнуудын тоон мэдээг нэгтгэн гаргах боломжтой болов.

### **2.5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

Албан бус-насан туршийн боловсролын төвүүдийн үйл ажиллагааны ололттой болон дутагдалтай тал, тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх гарц, авах арга хэмжээг тодруулах зорилгоор Баян-Өлгий, Сүхбаатар, Дархан-Уул, Орхон, Дорнод, Дорноговь, Хэнтий, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Төв, нийслэлийн 8 дүүрэг болон Хэнтий аймгийн Жаргалтхаан, Цэнхэрмандал, Баянхонгор аймгийн Шаргалжуут, Баян-Өлгий аймгийн Улаанхус, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумдын нэгжүүдэд ажиллаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Уг ажлын дүнд, тухайн Албан бус-насан туршийн боловсролын төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах талаар орон нутгийн удирдлагад санал зөвлөмжийг өгч хүргүүлснээс гадна нийтлэг тохиолдож буй бэрхшээлүүдийг шийдвэрлүүлэх талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад гаргаад байна.

Насан туршийн боловсролын төвөөс 12 сарын 1-нд тоон болон бичмэл тайлан бичих стандарт загварыг аймгийн Албан бус-насан туршийн боловсролын төвүүдийн албаны и-мэйл хаягаар явуулж 12-р сарын 15-ны дотор 21 аймаг, 9 дүүргийн бүхий л салбар нэгжүүдийн шаардагдах мэдээллийг боловсруулан ажиллаж байна.

## **2.6. БУСАД АЖИЛ**

2014 онд дээр дурдсанаас бусад ажлыг тоймлон дурдвал. Үүнд:

- Нийслэлийн Албан бус-насан туршийн боловсролын төвийн багш арга зүйчдийн дунд зохиогддог илтгэл, ур чадварын уралдааныг Насан туршийн боловсролын үндэсний төв, Хан Уул дүүргийн Албан бус-насан туршийн боловсролын төв хамтран хоёр дахь жилдээ зохион байгууллаа.
- Насан туршийн боловсролын үндэсний төвийн мэргэжилтнүүдийн ажлын байран дээрх ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ёс зүй, монгол бичиг,

боловсролын философи, судалгааны арга зүй, тусгай хэрэгцээт боловсрол, хэрэглээний боловсрол, нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, амьдрах ухааны ур чадвар дээшлүүлэх сургалтуудад хамруулав.

- Насан туршийн боловсролын чиглэлээр 2 удаа 1 цаг 10 минутын нэвтрүүлгийг бэлтгэж МҮОНТ-ээр хоёр удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлэв.
- Бүх нийтийн боловсролын 7 хоногийг тохиолдуулан “Боловсрол ба хөгжлийн бэрхшээл” сэдвийн хүрээнд 5 нэр төрлийн шторк бэлтгэж Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн цахим самбар болон Насан туршийн боловсролын үндэсний төвийн [www.nfde.mn](http://www.nfde.mn) сайтанд байршуулав.
- Нийслэлийн 6 дүүргийн Албан бус-насан туршийн боловсролын төвүүдийн тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 89 минутын танилцуулга бэлтгэн түгээв.
- Насан туршийн боловсролын сургалтын 5 чиглэл болох гэр бүл, иргэн, ёс суртахуун-төлөвшил, гоо зүйн-мэдрэмж, амьдрах ухааны чиглэлээр нийт 8 нэр төрлийн 7 цаг 53 минутын хичээлийг бэлтгэн түгээж, төвийн [www.nfde.mn](http://www.nfde.mn) сайтанд байршуулав.
- “Цагаан алтны эрдэм”, “Цэвэр орчны бүлгэм”, “Амжилтын зам”, “Мөнгө тарья” зэрэг 4 нэр төрлийн 9 цаг 49 минутын радио хичээлүүдийн эхийг дахин сайжруулав.
- БСШУЯ-ны туршилтын багтай хамтран Хүн байгаль, Төсөлт ажил сэдвээр Нийслэлийн Ерөнхий боловсролын 20 дугаар сургууль дээр 1 цаг 17 минутын захиалгат ажлыг хийв.
- Хөдөө орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын судалгаа (нийслэлийн 2 дүүрэг, 21 аймгийн Телевиз-61, FM, радио-34, сонин сэтгүүл- 27, вэбсайт- 19)-г авав. Албан бус-насан туршийн боловсролын төвүүд нь 22-Телевиз, 8-FM радио, 14-сонин сэтгүүл, 10-вэбсайттай хамтран хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, Албан бус-насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг сурталчилах зэргээр хамтран ажиллаж байна. Насан туршийн боловсролын чиглэлээр бэлтгэсэн 40 минутын нэвтрүүлгийг хөдөө орон нутгийн телевизээр цацаж насан туршийн боловсролын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ, ТӨЛӨВЛӨЛТ

### 3.1. ДҮГНЭЛТ

БСШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2014 оны ажлын үр дүнгээс хэд хэдэн зүйлийг энд онцлон тэмдэглэж байна. Үүнд:

- БШУ-ны сайдын 2013 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/242 тоот тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс 2,75 хэв.хууд “Насан туршийн боловсролын сургалтын багц хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж Боловсролын хүрээлэнгээр дүгнэлт гаргуулан 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр БСШУЯ-нд хүргүүлэв.
- Бүх нийтийн боловсрол-2015 үндэсний тайлангийн эхний төсөл (20 хэв.хууд)-ийг англи хэл дээр боловсруулан гаргаж ЮНЕСКО-д хүргүүлэв.
- БШУ-ны сайд аймаг, нийслэлийн засаг дарга нарт Насан туршийн боловсролын төв, нэгжийг байгуулах тухай 2013 оны 1а/5618 тоот албан даалгавар өгснөөр 2014 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар 359 насан туршийн боловсролын салбар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 21 төв, 338 нэгж ажиллаж байна.
- 1) Гэр бүлийн боловсрол; 2) Иргэний боловсрол; 3) Ёс суртахуун-төлөвшилийн боловсрол; 4) Гоо зүй-мэдрэмжийн боловсрол; 5) Амьдрах ухааны боловсролоос гэсэн үндсэн 5 чиглэлээр Албан бус-насан туршийн боловсролын төв, нэгжүүд нийт 182 576 суралцагчдад давхардсан тоогоор сургалт явуулав.

- Иргэдийн боловсролоо байнга, тасралтгүй дээшлүүлэх хэрэгцээг нь тандан судалж, тэдний боловсролын хэрэгцээ агуулгыг тодорхойлох зорилгоор Улаанбаатар хотын 8 дүүргийн 35315 иргэдийг хамруулсан насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээний судалгааг авч судалгааны тайланг гаргав. Мөн 2-дахь ээлжийн судалгаа болох 21 аймгийн 330 сумын 55727 насанд хүрэгчдээс хэрэгцээний судалгааг авч судалгааг SPSS програмд оруулахад бэлтгээд байна.
- *“Насан туршийн боловсролын өнөөгийн чиг хандлага”* сэдвийн хүрээнд Баян-Өлгий, Сүхбаатар, Дархан-Уул, Орхон, Дорнод, Дорноговь, Хэнтий, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, нийслэлийн 8 дүүрэг (9 аймаг, 8 дүүрэг)-ийн Албан бус - насан туршийн боловсролын төв болон нэгжийн давхардсан тоогоор 340, давхардаагүй тоогоор 257 багшийг хамруулсан сургалтыг зохион байгуулав.
- Орон нутагт иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцах боловсролын үйлчилгээг боловсронгуй болгох зорилготой үндэсний хэмжээний сургалт-семинарыг зохион байгуулав. Уг сургалт зохион байгуулагдсаны үр дүнд орон нутгийн удирдлага боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэлтэй болж, насанд хүрэгчдийн боловсролын ээлтэй үйлчилгээг явуулахад Албан бус-насан туршийн боловсролын төв, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд, хувь хүмүүсийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах талаар урьдчилсан төлөвлөгөөг гаргаж хэлэлцлэв.
- *“Бүх нийтийн боловсрол”* дэлхийн 7 хоногийг тохиолдуулан *“Боловсрол-хөгжлийн бэрхшээл: Тэгш эрх, тэгш боломж”* сэдвийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Боловсролд тэгш хамруулах тухай ойлголт хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн Газартай хамтран хэрэгжүүлж буй *“Залуучуудын хөгжил /2013-2017/”*-төслийг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр оролцов. Тус төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул, Орхон зэрэг нийт 11 аймаг, Улаанбаатар хотын Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Салбарын болон төвийн үйл ажиллагааг цахим хуудас, сэтгүүл, телевизийн нэвтрүүлэг, илтгэл, танилцуулга зэргээр дамжуулан сурталчлах замаар олон нийтийн насан туршийн боловсролын талаарх ойлголт, хандлагад нөлөөлж ажиллав.

***ХАВСРАЛТ 1.***

***Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөрийн төсөл***

***ХАВСРАЛТ 2.***

***Боловсролын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах санал***



***ХАВСРАЛТ 3.***

***Насан туршийн боловсролын сургалтын багц хөтөлбөр***

## Үндсэн 5 чиглэлийн сургалтад хамрагдагсад

№	Аймаг,	Гэр бүл	Иргэн	Ёс суртахуун төлөвшил	Гоо зүй мэдрэмж	Амьдрах ухаан	Нийт
1	Архангай	682	128	2222	938	407	4377
2	Баян-Өлгий	651	711	576	422	578	2938
3	Баянхонгор	4310	4405	6223	2571	4446	21955
4	Булган	712	1247	1311	749	903	4922
5	Говь-Алтай	150	234	82	111	2579	3156
6	Говьсүмбэр	195	125	94	180	458	1052
7	Дархан	123	162	26	114	120	545
8	Дорноговь	2614	2293	3784	2324	2121	13136
9	Дорнод	542	381	255	371	719	2268
10	Дундговь	84	50	15	49	156	354
11	Завхан	959	473	1020	630	696	3778
12	Орхон	419	500	1520	311	754	3504
13	Өвөрхангай	736	30134	25057	101	900	56928
14	Өмнөговь	787	571	311	199	1090	2958
15	Сүхбаатар	688	290	374	243	149	1744
16	Сэлэнгэ					Мэдээ ирээгүй	0
17	Төв	1722	2677	1844	1404	3526	11173
18	Увс	154	3640	1650	178	3005	8627
19	Ховд	1452	787	741	542	4249	7771
20	Хөвсгөл	628	773	735	696	418	3250
21	Хэнтий	755	384	300	84	3115	4638
22	Багануур	277	1153	2952	165	256	4803
23	Баянгол	150	149	746	271	48	1364
24	Баянзүрх	604	944	352	1095	815	3810
25	Налайх	296	336	280	45	267	1224
26	Сонгинохайрхан	471	996	201	180	146	1994
27	Сүхбаатар	130	250	130	165	65	740
28	Хан-Уул	1856	422	1447	57	5342	9124
29	Чингэлтэй	60	42	81	101	159	443
<b>Нийт дүн</b>		<b>22207</b>	<b>54257</b>	<b>54329</b>	<b>14296</b>	<b>37487</b>	<b>182576</b>

## Бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдагсад

№	Аймаг, дүүргийн нэр	Хамрагдсан сурагчдын тоо	Үүнээс			Үр дүн			
			бага	суурь	бүрэн дунд	ЕБС-ийн зохих ангид шилжин	Бага боловсрол эзэмшсэн	Суурь боловсрол эзэмшсэн гэрчилгээ авсан	Бүрэн дунд боловсролын гэрчилгээ авсан
1	Архангай	563	188	216	159				
2	Баян-Өлгий	423	182	154	87	100	182	46	28
3	Баянхонгор	765	198	225	342		134	119	179
4	Булган	188	36	82	70	1	30	47	63
5	Говь-Алтай	508	114	275	119	2	38	141	39
6	Говьсүмбэр	125	23	33	69		7	33	63
7	Дархан	247	83	164		11	107		
8	Дорноговь	78	22	56			22	43	
9	Дорнод	184	67	93	24	1	4	11	21
10	Дундговь	126	40	63	23				
11	Завхан	603	153	287	163			44	22
12	Орхон	104	44	28	32			18	29
13	Өвөрхангай	759	276	317	166				
14	Өмнөговь	133	52	63	18	2	13	37	18
15	Сүхбаатар	660	446	214					
16	Сэлэнгэ								
17	Төв	442	78	218	146	3	72	62	61
18	Увс	1004	240	507	257	11	54	207	118
19	Ховд	822	237	328	257	23	63	116	103
20	Хөвсгөл	962	525	352	85	35	213	137	54
21	Хэнтий	338	152	186					
22	Багануур	30	15	15		2	2	5	
23	Баянгол	64	27	26	11				
24	Баянзүрх	250	133	65	52	=	24	31	45
25	Налайх	167	46	73	48		17	27	26
26	Сонгинохай р-хан	140	74	54	12				
27	Сүхбаатар	120	56	42	22				
28	Хан-Уул	22	4	11	7		8	1	12
29	Чингэлтэй	192	74	47	71	2	78	40	41
Нийт дүн		10019	3585	4194	2240	193	1068	1165	919

## Бичиг үсгийн боловсрол олгох сургалад хамрагдагсад

№	Аймаг, дүүрэг	Нийт дүн	Эм	Түвшин				Сургалтын хэлбэр	
				Анхан	Дунд	Гүнзгий	Дараах	Өдрөөр	Бие дааж
1	Баянзүрх	50	5	31	19	0	0	19	31
2	Сүхбаатар	22	11	10	7	5	0	9	13
3	Сонгинохайрхан	45	20	17	7	4	17	45	0
4	Баянгол	11	4	5	6	0	0	11	0
5	Чингэлтэй	25	11	25	0	0	0	25	0
6	Хан-уул	15	7	15	0	0	0	15	0
7	Багануур	33	0	33	0	0	0	30	3
8	Багахангай	0	0	0	0	0	0	0	0
9	Налайх	36	1	36	0	0	0	36	0
<i>Улаанбаатар</i>		<i>237</i>	<i>59</i>	<i>172</i>	<i>39</i>	<i>9</i>	<i>17</i>	<i>190</i>	<i>47</i>
1	Архангай	112	53	28	45	29	10	112	0
2	Баян-Өлгий	305	153	31	58	95	121	294	11
3	Баянхонгор	344	50	160	107	47	30	150	194
4	Булган	Мэдээ ирээгүй							
5	Говь-Алтай	16	8	7	9	0	0	8	8
6	Говьсүмбэр	37	1	7	30	0	0	37	0
7	Дархан-Уул	60	15	16	44	0	0	52	8
8	Дорноговь	349	220	201	86	62	0	349	0
9	Дорнод	102	44	12	83	7	0	0	102
10	Дундговь	31	13	2	4	12	13	31	0
11	Завхан	78	35	14	28	21	15	64	14
12	Орхон	44	0	17	0	0	27	44	0
13	Өвөрхангай	290	190	145	85	24	36	290	0
14	Өмнөговь	24	5	11	13	0	0	17	7
15	Сүхбаатар	116	40	61	39	16	0	72	44
16	Сэлэнгэ	146	36	30	94	22	0	37	109
17	Төв	98	20	6	36	7	49	98	0
18	Увс	132	17	44	58	20	10	107	25
19	Ховд	388	159	124	143	81	40	89	299
20	Хөвсгөл	127	78	48	61	18	0	61	66
21	Хэнтий	377	155	16	39	283	39	57	320
<i>Орон нутаг</i>		<i>3176</i>	<i>1292</i>	<i>980</i>	<i>1062</i>	<i>744</i>	<i>390</i>	<i>1969</i>	<i>1207</i>
<b>Нийт дүн</b>		<b>3413</b>	<b>1351</b>	<b>1152</b>	<b>1101</b>	<b>753</b>	<b>407</b>	<b>2159</b>	<b>1254</b>